



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 11 сарын 01 өдөр

Дугаар A/536

Арвайхээр

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн “Үндсэн хөрөнгө дуудлага худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай” 2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 31 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн “Дуудлага худалдаа дахин зохион байгуулах тухай” A/502 дугаар захирамж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 25 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээд үндсэн хөрөнгө бий болгох, бүртгэх, худалдах, шилжүүлэх журам”-ын 3.13.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Дуудлага худалдаа дахин зохион байгуулах тухай” 2021 оны A/502 дугаар захирамжийн дагуу 2021 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн дуудлага худалдааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ц.Хашхүү (аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга)

Гишүүд: Э.Хорлоо (аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын татвар, төлбөр, үнэлгээний асуудал хариуцсан мэргэжилтэн)

Г.Ариунаа (аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын өмчийн бүртгэл, ашиглалт хариуцсан мэргэжилтэн)

2.Дуудлага худалдааг хууль, журмын дагуу зохион байгуулахыг ажлын хэсэг (Ц.Хашхүү)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

• 011101136